



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар A/08

Улаанбаатар хот

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг  
сонгон шалгаруулах, тэдгээрийн үйл ажиллагаанд  
баримтлах журам

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Оюуны өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.14 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, тэдгээрийн үйл ажиллагаанд баримтлах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА  Б.ЭНХСҮХ

Оюуны өмчийн газрын даргын  
2021 оны 01 сарын 27-ны өдрийн  
108 дугаар тушаалын хавсралт



## **Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сонгон шалгаруулалт, үйл ажиллагаанд баримтлах журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмыг Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага. /Оюуны өмчийн байгууллага/-аас олгосон оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгч дагаж мөрдөнө.

1.3. Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Оюуны өмчийн тухай хууль, Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хууль, Мэргэжлийн холбооны дүрэм болон бусад холбогдох дүрэм, журмаар зохицуулна.

1.4. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга ёсыг сахих, хүний эрх, эрх чөлөө, нэр хүнд, ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэх, нууц хадгалах, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн хүрээнд тууштай хамгаалах, хүнлэг, энэрэнгүй байх зарчмыг удирдлага болгоно.

### **Хоёр. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны дагнасан төрөл**

2.1. Итгэмжлэгдсэн төлөөлөгч мэргэжлийн үйл ажиллагааг оюуны өмчийн дараах салбараар дагнан эрхэлнэ:

2.1.1. патент;

2.1.2. барааны тэмдэг, газар зүйн заалт;

2.1.3. зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх.

2.2. Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Оюуны өмчийн тухай хуулийн 16.4.-д заасан шаардлагыг хангасан патентын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн байна.

2.3. Барааны тэмдэг, газар зүйн заалтын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Оюуны өмчийн тухай хуулийн 16.4-т заасан шаардлагыг хангасан барааны тэмдэг, газар зүйн заалтын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн байна.

2.4. Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Оюуны өмчийн тухай хуулийн 16.4-т заасан шаардлагыг хангасан, зохиогчийн эрх,

түүнд хамаарах эрхийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн байна.

2.5. Энэ журмын 2.2-2.4-т заасан аль нэг мэргэжлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь зөвхөн тухайн дагнасан тусгай зөвшөөрлийн нэршлийг хэрэглэнэ. Дагнасан мэргэжлийн үйл ажиллагааны бүх төрлөөр тусгай зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь “оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч” нэршлийг хэрэглэнэ.

### **Гурав. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сонгон шалгаруулах**

#### **3.1. Шалгалтыг зарлах, бүртгэх**

3.1.1. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шалгалт зарлах тухай Оюуны өмчийн байгууллагын дарга тушаал гаргах ба уг тушаалд Шалгалтын хорооны бүрэлдэхүүн болон шалгалтын хугацааг тодорхой заана.

3.1.2. шалгалтын товыг шалгалт эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө Оюуны өмчийн байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлана. Шалгалтын товд шалгалтын хуваарь, бүртгэх, шалгалт авах газар, хугацаа, шалгалтын дарааллыг заана.

3.1.3. шалгалтыг 3 жил тутамд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

3.2. Оюуны өмчийн тухай хуулийн 16.4-т заасан шаардлагыг хангасан иргэн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн шалгалтад бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлэн, шалгалтын хороонд ирүүлнэ.

3.2.1. өргөдөл;

3.2.2. иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

3.2.3. дээд боловсролын диплом, хуулбарын хамт;

3.2.4. оюуны өмчийн салбарт ажилласан тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

3.2.5. шалгалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт.

3.3. Шалгалтад оролцогчийн дээд боловсролын диплом болон ял шийтгэл, гэмт хэрэгт холбогдсон буюу сэжигтэн, ялгагдагчаар татагдсан эсэх лавлагааг шалгалтын хороо холбогдох байгууллагаас авч нягтлан шалгана.

3.4. Шалгалтын хороо нь дор дурдсан үндэслэлээр өргөдөл гаргагчийг шалгалтад оролцуулахаас татгалзах эрхтэй.

3.4.1. өргөдөл гаргагч энэхүү журмын 3.2-т заасан баримт бичгийг дутуу буюу хуурамчаар үйлдсэн бол;

3.4.2. шалгалтад оролцогчид тавигдах болзол, шаардлага хангаагүй бол;

3.4.3. хууль тогтоомжоор хориглосон нөхцөл байдал илэрсэн бол.

3.5. Шалгалтын хороо шалгалтын товоос 25-аас доошгүй хоногийн өмнө зохих шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид шалгалтад орох эрх олгож, нэрсийг баталгаажуулан бүртгэлийн хуудас олгоно.

3.6. Иргэн шалгалтад орохоор бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, худал мэдүүлсэн нь шалгалтын явцад, эсхүл шалгалтын дараа илэрсэн тохиолдолд тухайн иргэний шалгалтын үнэлгээг хүчингүйд тооцох үндэслэл болох бөгөөд үүнээс үүсэх хохирол, хариуцлагыг иргэн өөрөө хариуцна.

### 3.7. Шалгалт зохион байгуулах

3.7.1. энэ журмын 3.1.1-д заасан шалгалтын хороо шалгалтыг зохион байгуулна;

3.7.2. шалгалт нь оюуны өмчийн мэдлэгийг сорьсон сорилын шалгалт болон мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох ганцаарчилсан ярилцлагын хэлбэрээр явагдана.

3.7.3. сорилын шалгалт нь энэ журмын 2.1.1-2.1.3-д заасан төрөлтэй байна.

3.7.4. шалгалтад оролцогч сорилгын шалгалтын 100 онооноос 70 оноо авсан бол ярилцлагын шалгалтад оролцох эрхтэй болно.

### 3.8. Шалгалтын хороо:

3.8.1. шалгалтын хороо нь Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, Мэргэжлийн холбооны Удирдах зөвлөлийн төлөөллийг оролцуулан 7 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

3.8.2. шалгалтын хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.8.2.1. шалгаруулалтанд оролцогчийн баримт бичгийн бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, бүртгэх;

3.8.2.2. шалгалтын танхим, техник хэрэгсэл, компьютер болон шалгалт хэвийн явагдах бусад орчин, нөхцөлийг хангах;

3.8.2.3. шалгалтын явцад энэ журамд заасны дагуу шалгалтад оролцогчдод хяналт тавих, шалгалтын явцыг баримтжуулах;

3.8.2.4. сорилын болон ярилцлагын шалгалтын материалыг бэлтгэж, нууцлалыг хангаж, битүүмжлэх;

3.8.2.5. сорилын шалгалтын дүнг гаргаж, дүнг нийтэд мэдээлэх;

3.8.2.6. энэ журмын 3.7.4.-т заасан шалгуурыг хангасан оролцогчоос ярилцлагын шалгалт авч, шалгалтын нэгдсэн дүнг хуралдаанаар хэлэлцэж, гарсан шийдвэр болон бусад холбогдох материал, тусгай зөвшөөрөл олгох саналын хамт Оюуны өмчийн байгууллагын даргад хүргүүлэх;

3.8.2.7. шалгалттай холбоотой оролцогчоос гаргасан санал, хүсэлт, гомдлыг эрх үэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэж хариву өгөх, шаардлагатай

тохиолдолд Оюуны өмчийн байгууллагын даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

3.8.2.8. шалгалтын хороо болон Оюуны өмчийн байгууллагын даргын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.

### **Дөрөв. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн мэргэжлийн холбооны чиг үүрэг, зохион байгуулалт**

4.1. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн мэргэжлийн холбоо /цаашид Мэргэжлийн холбоо гэх/ нь итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, эрх ашгийг хамгаалах, хариуцлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх, иргэдийн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гишүүнчлэлтэй, мэргэжлийн өөрөө удирдах ёсны хуулийн этгээд байна.

4.2. Мэргэжлийн холбоо нь өөрийн тамга, бэлгэ тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тус холбооны Удирдах зөвлөлөөс баталсан тамга, бэлгэ тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх зааврыг мөрдөж ажиллана.

4.3. Төрийн болон төрийн бус байгууллага, түүний албан тушаалтны шийдвэр нь итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл Мэргэжлийн холбоо итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийг үндэслэн холбогдох байгууллага, албан тушаалтан, шүүхэд санал, гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.

4.4. Мэргэжлийн холбоо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.4.1. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн нэр хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, төрийн аль ч шатны байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид төлөөлөх;

4.4.2. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааны нэгдсэн шаардлага, Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх;

4.4.3. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг сурталчилан таниулах;

4.4.4. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шалгалт, үргэлжилсэн сургалт зохион байгуулах талаар Оюуны өмчийн байгууллагатай хамтран ажиллах;

4.4.5. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн ёс зүй, мэдлэг, ур чадвар, үзүүлж байгаа мэргэжлийн туслалцааны чанарыг дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг сайжруулах;

4.4.6. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааны явцад хохирсон төлөөлүүлэгчийн гомдлыг хүлээн авч, хэлэлцэх,

4.4.7. шаардлагатай тохиолдолд Ёс зүйн хорооны шийдвэрийг Оюуны өмчийн газарт хүргүүлэх;

4.4.8. хуульд заасан бусад чиг үүрэг.

4.5. Мэргэжлийн холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн их хурал байна. Түүний дэргэд ёс зүйн хороог байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад хороог зохион байгуулж болно.

4.6. Гүйцэтгэх захирал нь Мэргэжлийн холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх захирлаар холбооны гишүүн эсхүл оюуны өмчийн чиглэлээр мэргэшсэн хувь хүнийг ажиллуулж болно.

4.7. Мэргэжлийн холбоо нь өөрийн чиг үүрэг, өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын албатай байж болно. Ажлын албаны ажилтан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд байна. Хэрэв итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бол уг эрхийг түдгэлзүүлнэ.

4.8. Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.8.1. Их хурал, Удирдах зөвлөл, Удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирлын шийдвэр, холбогдох хууль тогтоомжид нийцсэн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

4.8.2. мэргэжлийн холбооны өдөр тутмын үйл ажиллагаа, Ёс зүйн хороо болон мэргэжлийн холбооны ажлын уялдаа холбоог зохион байгуулах;

4.8.3. мэргэжлийн холбоог мэдээллээр хангах, тэдгээрийн хооронд мэдээлэл, туршлага солилцох боломжийг бүрдүүлэх;

4.8.4. бүх гишүүдийн хурал болон Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох шийдвэрийн төслийг бэлтгэх;

4.8.5. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулах;

4.8.6. мэргэжлийн холбооны гишүүдийн бүртгэлийг хариуцан хөтлөх, цахим сан бүрдүүлэх, Мэргэжлийн холбооны цахим хуудсанд байршуулах;

4.8.7. хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр тэдгээрийг Мэргэжлийн холбооны талаарх мэдээллээр хангах;

4.8.8. холбооны дүрэмд заасан бусад чиг үүрэг.

4.9. Мэргэжлийн холбооны хөрөнгө нь гишүүнчлэлийн хураамж, хандив, тусламж, үргэлжилсэн сургалтын хураамж, хэвлэн нийтлэлийн орлогоос бүрдэнэ.

4.10. Мэргэжлийн холбооны үйл ажиллагаа болон санхүү, төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт нь холбооны гишүүд болон олон нийтэд нээлттэй байна.

4.11. Энэ журмаар зохицуулаагүй харилцааг Оюуны өмчийн мэргэжлийн холбооны дүрмээр зохицуулна.

**Тав. Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг**

5.1. Оюуны өмчийн байгууллага нь Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

5.1.1. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг эрх хэмжээний хүрээнд зохион байгуулах;

5.1.2. итгэмжлэгдсэн төлөөлөгчийг Оюуны өмчийн байгууллагаас батлагдсан хөтөлбөр, журмын дагуу бэлтгэх, сургах, давтан сургах ажлыг Мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулах;

5.1.3. энэ журмын 3.1-т заасан Шалгалтын хороо байгуулах;

5.1.4. энэ журмын 3.8.2.6.-д заасны дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн Шалгалтын хорооны шийдвэр болон бусад холбогдох баримт бичиг, тусгай зөвшөөрөл олгох саналыг үндэслэн үйл ажиллагааны төрлийг заасан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох;

5.1.5. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, тэдгээрт өөрчлөлт оруулах;

5.1.6. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосонтой холбоотой шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногт багтаан энэ журмын 5.1.5-т заасан мэдээллийн санд өөрчлөлт оруулж, олон нийтэд мэдээлэх;

5.1.7. энэ журмын 3.2-т заасан холбогдох материалыг архивлах;

5.1.8. тусгай зөвшөөрөл бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчийн сургалтад хамрагдан, 2 багц цаг хангасан эсэхийг 2 жил тутам дүгнэх;

5.1.9. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулж гаргасан өргөдөл, гомдол хүлээн авах, хянан шийдвэрлэх;

5.1.10. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн энэ журмын 8 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

5.1.11. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн энэ журмын 9 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

5.1.12. мэргэжлийн холбооны саналыг үндэслэн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг шагнаж урамшуулах, эрх бүхий байгууллагад тодорхойлох.

5.2. Оюуны өмчийн байгууллагад 10-аас дээш жил шинжээчээр ажилласан хүн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах хүсэлт гаргасан тохиолдолд уг хүсэлтийг үндэслэн энэ журмын 3 дугаар зүйлд заасан дагнасан төрлөөр тусгай зөвшөөрөл олгож болно.

5.3. Энэ журмын 5.2-т заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь холбогдох хууль журамд нийцсэн байна.

**Зургаа. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүрэг**

6.1.1. Патентын тухай хууль болон Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу олгогдсон итгэмжлэлийн хүрээнд мэдүүлэг гаргах, нэмэлт өөрчлөлт оруулах, няцаалт, нотолгоо, хариу тайлбар, хүсэлт, гомдол гаргах;

6.1.2. оюуны өмчийн байгууллагын дэргэдэх Маргаан шийдвэрлэх комисст төлөөлүүлэгчээс олгогдсон итгэмжлэлийн хүрээнд гомдол, тайлбар, хүсэлт, татгалзал гаргах, маргаан бүхий хэргийн материал, нотлох баримттай танилцах;

6.1.3. маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цугларсан нотлох баримттай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, хуулбарлан авах, маргаан шийдвэрлэх хуралд оролцох;

6.1.4. маргаан шийдвэрлэх зөвлөлийн шийдвэрт давж заалдах;

6.1.5. оюуны өмчийн мэргэжлийн үйл ажиллагаа үзүүлэхдээ төлөөлүүлэгчээс хөлс авах бөгөөд хэмжээг төлөөлүүлэгчтэй гэрээгээр харилцан тохиролцож тогтоох;

6.1.6. хуульд заасан бусад

6.2. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаагаа ганцаарчилан, гэрээгээр хамтарч эсхүл хуулийн этгээд байгуулан эрхэлж болно.

6.3. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах нийтлэг үүрэг

6.3.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон оюуны өмчийн олон улсын гэрээ, хэлэлцээр, Оюуны өмчийн хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх;

6.3.1.2. мэргэжлийн холбооны гишүүн байж, гишүүнчлэлийн хураамж төлөх;

6.3.1.3. мэргэжлийн холбооноос зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;

6.3.1.4. оюуны өмчийн байгууллагаас зохион байгуулах үргэлжилсэн сургалтад хамрагдаж, оюуны өмчийн байгууллагаас баталсан хөтөлбөрийн дагуу багц цаг хангах;

6.3.1.5. хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа хууль бус үйлдэл хийхгүй байх, төлөөлүүлэгч болон бусад этгээдтэй харилцахдаа хүндэтгэлтэй хандах;

6.3.1.6. төлөөлүүлэгч болон бусад этгээдийн хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах;

6.3.1.7. төлөөлүүлэгчээс олгогдсон итгэмжлэлийн хүрээнд гүйцэтгэсэн аливаа үйл ажиллагааны талаар тухай бүр мэдэгдэх, зөвлөгөө өгөх;

6.3.1.8. төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, шийдвэрийг



хүндэтгэх;

6.3.1.9. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон Мэргэжлийн ёс зүйн дүрмийг /цаашид “Ёс зүйн дүрэм” гэх/ баримтлах;

6.3.1.10. итгэмжлэгдсэн төлөөлөгч оюуны өмчийн мэргэжлийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байр, шаардлагатай техник тоног төхөөрөмжтэй байх;

6.3.1.11. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн харилцах цахим хаяг, байршлын хаяг, утасны дугаар өөрчлөгдсөн бол шинэчлэгдсэн мэдээллийг Оюуны өмчийн газарт бичгээр мэдэгдэнэ.

6.3.1.12. итгэмжлэгдсэн төлөөлөгч, оюуны өмчийн хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, бусад шаардлагатай мэдээлэлд өөрчлөлт орсон бол 14 хоногийн дотор Оюуны өмчийн газарт бичгээр мэдэгдэнэ.

6.3.1.13. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

6.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгч мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдаж болно.

6.5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах үйлдлийг хориглоно. Болохгүй, зөвшөөрөхгүй

6.5.1. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээлэл, нууц задруулах;

6.5.2. ёс зүйн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг тийм үйлдэл хийхэд нөлөөлөх;

6.5.3. итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууран мэхлэх, хууль бус аргаар явуулах;

6.5.4. төрийн байгууллага, албан тушаалтанд зүй бусаар нөлөөлөх, давуу эрх эдлэх эсхүл хууль тогтоомж болон мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчин хүссэн үр дүндээ хүрч чадах мэт илэрхийлэх;

6.5.5. мэдүүлэг болон бусад нотлох баримтыг хуурамч гэдгийг мэдсээр байж мэргэжлийн үйл ажиллагаанд ашиглах;

6.5.6. албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс нөлөөлөх, гүтгэх;

6.5.7. төрийн албан хаагчид шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;

6.5.8. итгэмжлэгдсэн төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгогдсон итгэмжлэлийн хугацаа дуусахаас өмнө хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлөөлөх үүргээс татгалзах;

6.5.9. мэргэжлийн үйл ажиллагаанд шударга бусаар өрсөлдөх.

**Долоо. Оюуны өмчийн хуулийн этгээд**

7.1. Оюуны өмчийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь хязгаарлагдмал хариуцлагатай компани эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэртэй байна.

7.2. Оюуны өмчийн хуулийн этгээдийн оноосон нэрийн өмнө «Оюуны өмчийн» гэсэн үгийг хэрэглэнэ.

7.3. Оюуны өмчийн хуулийн этгээдийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 14 хоногийн дотор Оюуны өмчийн байгууллагад бүртгүүлнэ.

7.4. Оюуны өмчийн хуулийн этгээдийг Оюуны өмчийн байгууллагад бүртгүүлэхэд дараах бичиг баримтыг бүртгүүлнэ.

7.4.1. Хүсэлт;

7.4.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хуулбарын хамт;

7.4.3. Тухайн хуулийн этгээдийг удирдах болон төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгч бусад гишүүдийн тухай мэдээлэл, товч танилцуулга;

7.4.4. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гэрчилгээний хуулбар;

7.4.5. Ажлын байрны мэдээлэл.

7.5. Энэ журмын 7.1-т заасан хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч нь гурваас доошгүй оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч байна.

7.6. Оюуны өмчийн хуулийн этгээд нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээдтэй хамтарч ашиг хуваах байдлаар үйл ажиллагаа эрхэлж болохгүй.

### **Найм. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

8.1. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд Оюуны өмчийн байгууллагын даргын шийдвэрээр түдгэлзүүлнэ.

8.1.1. жирэмсний болон амаржсаны амралт авсан, хүүхэд асрах чөлөөтэй байгаа бол ажилдаа эргэн орох хүртэл хугацаанд;

8.1.2. хүндээр өвдсөн бол эдгэх хүртэл хугацаанд;

8.1.3. гадаад улсад удаан хугацаагаар суралцах болсон бол Монгол Улсад эргэн ирэх хүртэл хугацаанд;

8.1.4. итгэмжлэгдсэн төлөөлөгч эрүүгийн хариуцлагад татагдаж хорих ял эдлэх болсон бол хорих ялын хугацаанд;

8.1.5. итгэмжлэгдсэн төлөөлөгч гадаад улсад 180 хоногоос дээш хугацаагаар оршин суух бол Монгол улсад эргэн ирэх хүртэл хугацаанд.

8.2. Энэ журмын 8.1.1-8.1.3-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг

түдгэлзүүлэхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэнэ.

8.3. Энэ журмын 8.1.5-д заасан нөхцөл үүссэн бол итгэмжлэгдсэн төлөөлөгч Оюуны өмчийн газарт урьдчилан бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

8.4. Энэ журмын 8.1-д заасан үндэслэл арилж, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх сэргээх хүсэлтэд үндэслэн Оюуны өмчийн байгууллагын дарга мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

8.5. Мэргэжлийн холбооны саналд үндэслэн ёс зүйн зөрчил гаргасан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг 2 жил хүртэл хугацаагаар Оюуны өмчийн байгууллагын дарга түдгэлзүүлнэ.

8.6. Энэ журмын 8.1.5-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл нь түдгэлзсэн бол түдгэлзүүлэх үндэслэл арилснаас хойш 2 жилийн дотор хүсэлт гаргаж, эрхээ сэргээлгэж болно.

### **Ес. Оюуны өмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

9.1. Оюуны өмчийн байгууллагын дарга дараах тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

9.1.1. мэргэжлийн холбооны Ёс зүйн хорооны саналыг үндэслэн;

9.1.2. мэргэжлийн холбооны Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн;

9.1.3. итгэмжлэгдсэн төлөөлөгч Монгол Улсын харъяатаас гарсан;

9.1.4. итгэмжлэгдсэн төлөөлөгч тусгай зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн;

9.1.5. гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож эрүүгийн ял эдлүүлэх шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болсон;

9.1.6. итгэмжлэгдсэн төлөөлөгч эрх зүйн чадамжгүй болсон;

9.1.7. итгэмжлэгдсэн төлөөлөгч мэргэжлийн алдаа гаргасан нь төлөөлүүлэгчийн эрх ашигт ноцтой хохирол учруулсан болох нь нотлогдсон;

9.1.8. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаагүй, багц цаг хангаагүй;

9.1.9. итгэмжлэгдсэн төлөөлөгч нас барсан тохиолдолд;

9.1.10. хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан;

9.1.11. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацаанд үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд эсвэл тийм зөрчил давтан гаргасан тохиолдолд;

9.1.12. энэ журмын 8.3-д заасан мэдэгдэх үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол

9.1.13. энэ журмын 8.6-д заасан хугацаанд эрх сэргээлгэх хүсэлт гаргаагүй бол.

9.2. Оюуны өмчийн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн хэн нэгний оюуны өмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл түдгэлзэх, хүчингүй болох эсхүл үүсгэн байгуулагчийн тоо энэ журамд заасан тооноос цөөн болсон тохиолдолд оюуны өмчийн байгууллагын шийдвэрээр хүчингүй болгож, бүртгэлээс хасна.

9.3. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд энэ талаар гомдол гаргах эрхтэй.

9.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд тухайн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлүүлэгчийн дуусгавар болоогүй үүргийг өөр итгэмжлэгдсэн төлөөлөгчид шилжүүлэх журмыг Мэргэжлийн холбоо батална.

#### **Арав. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны талаар гомдол гаргах**

10.1. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, оюуны өмчийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны талаарх гомдлыг Оюуны өмчийн байгууллагад гаргана.

10.2. Итгэмжлэгдсэн төлөөлөгч болон төлөөлүүлэгчийн хооронд үүссэн маргааны талаарх гомдлыг Мэргэжлийн холбоонд гаргана;

10.3. Энэ журмын 10.1, 10.2-т заасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

#### **Арван нэг. Бусад**

11.1. Энэ журмын хэрэгжилтэд Оюуны өмчийн байгууллага хяналт тавьж ажиллана.

11.2. Энэ журмын 2.1-2.4-т заасан зүйлийг буцаан хэрэглэхгүй.